

БАТЛАВ:

СУРГАЛТ, ОЮУТАН ХАРИУЦСАН ДЭД  
ЗАХИРАЛ

Д-р Д.БАДМААНЯМБУУ

УХД0072 9104399

2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МУИС-ИЙН ОЮУТНЫ  
УРЛАГИЙН ИХ НААДМЫН УДИРДАМЖ

**Зорилго:** МУИС-ийн 80 жилийн ойн ажлын хүрээнд ардын уламжлалт болон орчин үеийн урлагаар дамжуулан оюутан залууст эерэг соёлыг түгээх мөн МУИС-ийн соёл оюутан хоорондын харилцааг бэхжүүлэх. МУИС-ийн урлагийн авьяастай оюутан залуучуудыг шалгаруулж МУИС-ийн оюутны нэгдсэн урлагийн тоглолт зохион байгуулна:

**Үр дүн, ач холбогдол:**

- МУИС-ийн оюутны урлагийн баг, хамтлагуудыг бэлтгэх
- Оюутны урлаг, уран сайхны боловсролыг дээшлүүлэх
- 80 жилийн ойн хүрээнд багш, ажилчид, суралцагчдад зориулсан үнэ төлбөргүй урлагийн их наадмын шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн тоглолт зохион байгуулах.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхэд болон ахмадын асрамжийн газар, хүүхдийн хорих анги болон хотоос зайд орших ЕБС-д урлагийн их наадмын шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн тоглолт зохион байгуулах.

**Сэдэв:** “МУИС-ийн 80 жилийн ой”

**Хамрах хүрээ:** МУИС-ийн бакалаврын түвшний оюутнууд

**Хугацаа:** 2022.04.17-ний 09:00 цагт

**Хаана:** Улаанбаатар театрын концертын их танхимд /Хуучнаар УБ Чуулга/

**Ерөнхий төлөвлөгөө**

№	Урлагийн их наадмын хөтөлбөр		Огноо	Цаг
1	Хөтлөгч их наадмыг эхлүүлнэ	МУИС-ийн урлагийн их наадмыг эхлүүлнэ	2022.04.17	09:00
2	Мэндчилгээ	Бүх салбар сургууль		09:10
3	Гоцлол эсвэл хоршил хөгжим	Бүх салбар сургууль		10:30
4	Хамтлаг бүжиг	Бүх салбар сургууль		12:50
5	Завсарлага	Цайны завсарлага		13:20
6	Нээлт	МУИС-ийн захирал Б.Очирхуяг үг хэлнэ Бүрэлдэхүүн сургуулийн захирал нар оролцно.		13:20
7	Гоцлол дуу	Бүх салбар сургууль		14:40
8	Ардын болон язгуур урлаг	Бүх салбар сургууль		15:20
9	Хамтлаг дуу	Бүх салбар сургууль		16:40

10	Хамтлаг бүжиг чөлөөт	Бүх салбар сургууль		17:00
11	Шагнал гардуулах ёслол	Үзүүлбэр тус бүрээр шагналт байруудыг шагнах, шилдэг сургуулийг шалгаруулна.		17:40
12	Хаалт	Хаалтын үг, Урлагийн их наадамд оролцогчид зураг даруулна.		18:00

**Тайлан тоглолт (багш, ажилтан, суралцагчдад)**

№	Үйл ажиллагааны нэр	Хаана	Огноо	Цаг
1	Урлагийн их наадмын шилдэг үзүүлбэрийн тоглолт	Тусгаар тогтнолын ордон	2022.04.29	17:00-18:30

**Тайлан тоглолт (ахмадын болон хүүхдийн асрамжийн газар)**

1	Урлагийн их наадмын шилдэг үзүүлбэрийн тоглолт	Хүүхдийн асрамжийн газар	2022.05.05	11:00-16:30
2		Ахмадын асрамжийн газар	5	
3		Хүүхдийн засан хүмүүжүүлэх газар	2022.05.06	11:00-16:30
4		Хотоос алслагдсан ЕБС-д	6	

**Зохион байгуулагчид:**

1. МУИС-ийн Оюутан, төгсөгчийн хэлтэс
2. МУИС-ийн Оюутны холбоо хамтран зохион байгуулах

**Шалгуур үзүүлэлт:**

- Ур чадвар
- Бэлтгэл, бичлэг болон хөгжмийн зэмсэг, ая шаардлага хангасан байдал
- Тайзны соёл, хувцаслалт
- Бэлтгэл зохион байгуулалт, найруулга агуулга сайн байх

**Хөтөлбөр:** Урлагийн наадам нь нийт 7 төрлөөр явагдана. Үүнд:

- **Мэндчилгээ:** (МУИС-ийн 80 жилийн ойн баяр) бүрэлдэхүүн, салбар сургууль, хөтөлбөрийн онцлог, түүхэн он жилүүд, оюутны амьдралыг харуулсан байх.
- **Гоцлол эсвэл хоршил хөгжим** /3-5 минут/
- **Хамтлаг бүжиг** /цэнгээнт бүжиг 5 минутаас ихгүй байх, 8 хос 16 гишүүнтэй байх/
- **Гоцлол дуу** /3-5 минут сонгодог, эстрад, бусад/
- **Ардын болон язгуур урлаг** /3-5 минут хөөмий, исгэрээ, бие биелгээ, магтаал, тууль гэх мэт язгуур үзүүлбэрүүд байх багууд 10-с илүүгүй оролцогчтой байна.
- **Хамтлаг дуу** /3-5 минут сонгодог, эстрад, бусад/
- **Хамтлаг бүжиг чөлөөт** /4-6 минут, багийн нийт гишүүд 15-аас илүүгүй оролцогчтой байна/

**Тавигдах шаардлага:**

- МУИС-ийн оюутан байх
- Салбар сургуулийн “Оюутны зөвлөл”-дөө оролцох төрөл үзүүлбэрээ урьдчилан мэдэгдэж бүртгүүлсэн байх

- Удирдамжид заасан дагуу хугацаа, ая, хөгжим, хувцас тайзны жижиг хэрэгсэл бусад бэлтгэлээ урьдчилан хангасан байх
- Үзүүлбэр тодорхой, ойлгомжтой тоглолтын ерөнхий зохиомжид нийцсэн байх
- Урлагийн тоглолт үзүүлбэрийн үед шүүгчид, бусад оролцогчид, хамт олноо хүндэтгэн оролцох
- Үзүүлбэр эхлэхээс өмнө багийн бэлтгэлийг хангаж байраа эзэлсэн байх
- Багууд мэдүүлгийнхээ дагуу оролцох
- Шүүгчид, зохион байгуулагчдын гаргасан шийдвэр үнэлгээг хүлээн зөвшөөрч соёлтой оролцох
- Баг тус бүр өөрийн багийн оролцогч гишүүд болон багийн нийт гишүүдийн нэрс, үзүүлбэрийн нэрийг урьдчилан мэдүүлсэн мэдүүлгийг 2022.04.14-нд 17:00 цагаас өмнө хичээлийн 2-р 110 тоотод ирүүлсэн байх.
- Багийн мэдүүлэг урьдчилан ирүүлээгүй баг хамт олны багийн нийлбэр онооноос 2 бүхэл оноо хасна.

#### **Дүгнэх, шалгаруулах журам:**

- Урлагийн наадмыг мэргэжлийн шүүгчид дүгнэж шалгаруулна.
- Оноог нийтэд ил тод нээлттэй өргөж танилцуулах бөгөөд шүүгч тус бүр 1-5,5 оноогоор дүгнэнэ.
- Үзүүлбэр тус бүрт тайзны соёл, хувцаслалт баг хамт олны зохион байгуулалт зэргийг харгалзан үзэж дүгнэнэ.
- Үзүүлбэр тус бүрийг заасан хугацаанд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих хөндлөнгийн шүүгч ажиллах бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд .... оноог үзүүлбэрээс хасч дүгнэх
- Шилдэг үзүүлбэр тус бүр 1, 2, 3 дугаар байр эзлүүлэх ба үзүүлбэр тус бүрийн тэргүүн байрыг мөнгөн шагнал дагалдана.
- Шилдэг багаар 1, 2, 3 дугаар байрт шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагнал гардуулна.
- Шилдгээр шалгарсан үзүүлбэр, хамт олны тоглолтыг нэгтгэн “Урлагийн наадмын шилдэг үзүүлбэрийн тоглолт-2022”-д оролцуулна.

Хянасан:



Оюутан, төгсөгчийн хэлтсийн дарга Д-р  
М.Эрдэнэчимэг



Оюутан, төгсөгчийн хэлтсийн ахлах  
мэргэжилтэн Л.Чинзориг

Боловсруулсан:



Оюутан, төгсөгчийн хэлтсийн  
мэргэжилтэн Ц.Билгүүн